

АУДИТЫН ТАЙЛАНГ
БЭЛТГЭСЭН:

Булган аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх
аудитор
Д.Анхбаяр

Аудитын менежер
Ж.Энхцоодол

Ахлах аудитор
Г.Намчинсүрэн

2018 оны 05 дугаар
сар

Уг тайланг аймгийн
Төрийн аудитын
газраас авч үзнэ үү:

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70342495, 70342716
утасаар
факс:70342580
дугаараар харилцана
уу

ХАЯГ:

Булган сум 5-р баг
Нутгийн удирдлагын
ордон
Өрөө № 401 тоот

Товчилсон үгийн тайлбар.....3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга, зүй, шалгуур
үзүүлэлт.....4-5

Бүлэг 1. *Үйл ажиллагааны төлөвлөвлөгөө, үр дүнгийн
гэрээгээр хүлээсэн үүргээ 78.9 хувь хэрэгжүүлэн ажилласан
байна.....5-6*

Бүлэг 2. *Үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй
төлөвлөөгүй, үйл ажиллагааны зардлыг бүлэг хооронд
шилжүүлэн зарцуулсан, байгаль хамгаалах нөхөн сэргээх
зардлын 22.8 хувийг үндсэн үйл ажиллагааны зардалд
зарцуулсан байна.....6-8*

Бүлэг 3. *Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгалтын
мөрөөр нөхөн байршуулсан байна.....9*

Дүгнэлт.....9-10

Зөвлөмж.....10

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
БУАТАГ	Булган аймаг дахь Төрийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БЦГ	Байгалийн цогцолборт газар
ХТБЦГЗ	Хөгнө тарнын байгалийн цогцолборт газрын судалгаа
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨ	Орон нутгийн өмчит
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Булган аймаг дахь Төрийн Аудитын газрын 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт:

Гол усны сав газар болон тусгай хамгаалалттай газруудад хэрэгжиж байгаа хууль, журмын хэрэгжилтийн үр дүнд нийцлийн аудит хийж дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээллэхэд аудитын зорилт чиглэгдээ.

3. Аудитын хамрах хүрээ:

Хөгнө тарна байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2017 оны санхүүгийн үйл ажиллагаа, түүнтэй холбогдох судалгаа, нотлох баримт, бусад тусгай сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн гүйцэтгэл тус тус хамрагдлаа.

4. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-100, 4000, 4100 дугаар стандартууд болон, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгадагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгаж, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийж, судалгаа тодруулга авч, хэрэгжүүлэгч байгууллагын тайлан, баримт, материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийж, зарим арга хэмжээнээс түүвэрчлэн шалгах зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5. Аудитад ашиглагдах хууль, тогтомж, шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрхийн акт, холбогдох бичиг баримтыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглааа. Үүнд:

- + Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- + Төрийн аудитын тухай хууль,
- + Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- + Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
- + Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль
- + Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- + Холбогдох бусад хууль, эрх зүйн акт, тушаал, шийдвэр

6. Аудитын тайлан:

Аудитын тайлан нь энгийн, тодорхой, хоорондийн уялдаа холбоотой байх бөгөөд ерөнхий зүйл, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, байгууллагын удирдах албан тушаалтаны санал болон хавсралт судалгаа тооцоо, тайлбаруудаас бүрдэнэ.

Аудитын тайлангийн төслийг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч аудитын удирдагчид танилцуулан баталгаажууллаа.

Ерөнхий мэдээлэл: Хөгнө тарнын байгалийн цогцолборт газрын хамгааллатын захиргаа нь Гурванбулаг, Рашаант, Өвөрхангай аймгийн Бүрд сумдын газар нутгийг хамарсан нийт 84390 га талбайг эзэлдэг. Байгууллагын эрхэм зорилго нь БЦГ-ын экосистемийн тэнцвэрт байдал, унаган төрх, биологийн олон янзын байдлыг хадгалан хамгаалах, судлан шинжлэх, аялал жуучлалыг хөгжүүлэх замаар байгалийн баялгийг зохистой ашиглахад нутгийн иргэдтэй хамтран ажиллах, хууль тогтоомж, эрх зүйн бусад стандартыг хэрэгжүүлэхэд чиглэгддэг байна. Хамгаалалтын захиргааны төрийн сангийн дансанд нэгдүгээр гарын үсгийг хамгаалалтын захиргааны дарга Д.Эрдэнэчимэг, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Ганболд нар зурж төсөв санхүүгийн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллажээ.

*Булган аймаг дахь
Төрийн Аудитын газар*

*Хуульд заасан үндсэн чиг үүргээ чанартай,
хүртээмжтэй, бүрэн хэрэгжүүлж байна уу?*

Бүлэг 1

Үйл ажиллагааны төлөвлөвлөгөө, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ 78.9 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

1.1. Дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө болон үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үндсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллаагүй байна.

Тус байгууллага нь Төсвийн тухай хуулийн 40.2-д “Энэ хуулийн 40.1-д заасан үр дүнгийн гэрээнд байгууллагын төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, тэдгээрийн төсөв,хүрэх үр, түүнийг дүгнэх талаар тусгасан байна” гэж заасны дагуу тухайн жилд дэвшүүлсэн зорилт, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 35.1, 36.1-д заасан эрх, Хөгнө тарнын байгалийн цогцолборт газрын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан 2017 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлуудын дагуу тухайн жилд нийт 65 ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөжээ.

Үйл ажиллагааны төлөвлөгөө болон үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан тусгай арга хэмжээний 9, тусгай арга хэмнээс бусад 47 , манлайллын зорилтын 9 төлөвлөгөөт ажил тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан 78.9 хувь буюу “С” хангалттай гэж дүгнүүлж Төсвийн тухай хуулийн 40.3-д “Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас бүтэн жилээр дүгнэнэ” гэж заасан заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Хэдийгээр үйл

ажиллагааны төлөвлөгөөг хангалттай гэж дүгнүүлсэн боловч гүйцэтгэсэн ажлуудын гүйцэтгэлийг түүвэрлэн үзэхэд /хавсралт-1/ төлөвлөгөөт ажлаас 1 ажил огт хийгдээгүй, 5 ажил 50 болон түүнээс доош хувьтай биелсэн байна. Иймд үр дүнгийн гэрээнд тусгагдсан төлөвлөгөөт ажлуудын хэрэгжилтэнд хяналт тавих, дотоод хяналтыг сайжруулах хэрэгтэй байна.

1.2.Байгууллагын бүтэц, орон тоог батлагдсан орон тоонд багтаан ажилласан ба ТХГН-ийн байгаль хамгаалагчийн хариуцан хамгаалах талбайн хэмжээ холбогдох тогтоолд зааснаас 2 дахин илүү газар ногдож байна.

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын сайдын тушаалаар Удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 6, үйлчлэх ажилтан 3, гэрээт ажилчин 1 нийт 11 орон тоотойгоор баталсан байна. Нярав, бичиг хэрэг архив дотоод ажил хариуцсан 1 орон тоог хэмнэж жолоочид нярав, бичиг хэрэг архивыг нягтлан бодогчид хариуцуулан хавсаран ажилласан нэмэгдэл олгон ажиллажээ.

Хөгнө тарнийн байгалийн цогцолборт газрын хэмжээ нийт 84390 га талбай бөгөөд нэг байгаль хамгаалагчийн хариуцах тайлбайн хэмжээ нь дунджаар 28130 га талбай ногдож байна.Энэ нь Засгийн газрын 2006 оны 87 дугаар тогтоолоор байгаль хамгаалагчийн хариуцан хамгаалах талбайн хэмжээг тусгай хамгаалалттай газрын анилал, байгалийн бүс, бүслүүрийн онцлогоос шалтгаалж тал хээрийн бүсэд 100000 га талбайгаар тогтоосон байдагтай нийцэхгүй, нэг байгаль хамгаалагчид 2 дахин илүү газар ногдож байгаа нь хариуцсан газар нутагтаа тогтмол эргүүл хийж тавих хяналт тавих ажил цалгардах, хяналт шалгалт хийхэд хүдрэл учруулах эрсдэлтэй байна.

*Булган аймаг дахь
Төрийн Аудитын газар*

*Санхүүгийн үйл ажиллагаа холбогдох
хууль, дүрэм журамд нийсэн эсэх*

Бүлэг 2

Үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй, үйл ажиллагааны зардлыг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан, байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын 22.8 хувийг үндсэн үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

2.1. Үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй, холбогдох хууль эрх зүйн актын дагуу бүрэн төвөрүүлээгүй байна.

Байгууллагын үйл ажиллагааны орлогыг 3200.0 мянган төгрөгөөр төлөвлөн батлуулж гүйцэтгэлээр 4017.2 мянган төгрөг буюу 817.2 мянган төгрөгийн өөрийн орлогоос давуулан биелүүлж, давсан орлогоос 148.0 мянган төгрөгийг зарцуулж нийт 3869.2 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Үйл ажиллагааны орлогын төлөвлөлтийг судлан үзэхэд төлөвлөгөөг бодитой тоо, тооцоо судалгаанд үнэдэслэдэггүй, зөвхөн өмнөх онуудын төлөвлөлтөнд тулгуурлан төлөвлөдөг байна. Энэ нь орлогын төлөвлөгөөний биелэлт үндэслэлгүй дүгнэгдэх, өөрийн орлогыг нэмэгдүүлэхэд идэвхи санаачлагагүй байх эрсдэлтэй байна.

Үйл ажиллагааны орлогын биелэлтийг судлан үзэхэд Байгаль орчны сайдын 2002 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 117 тоот тушаалын дагуу тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэн ороход гадаадын иргэдээс 3000, дотоодын иргэдээс 300 төгрөгийн хураамж авдаг байна. Тайлант онд байгаль хамгаалах 3 байцаагч нэвтрэх хураамжийн орлого 1167.0, тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аялал жуучлалын үйл ажиллагаа явуулж байгаа иргэдээс 470.5 мянган төгрөгийг тус тус оруулсан, 11 аж ахуй нэгж байгууллагатай нийт 4617.2 мянган төгрөгийн гэрээ байгуулснаас 4017.2 мянган төгрөгийг оруулж 2 аж, ахуй нэгжийн гэрээний дагуу нийт 600.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй зөрчилд төлбөрийг барагдуулах акт тогтоолоо.

Дээрхээс дүгнэхэд үйл ажиллагааны орлогыг бодитой тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

2.2. Бусад төсөл сангаас хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, холбогдох хууль, дүрэм журамд нийцсэн байна.

Тус онд Байгаль орчин аялал жуучлалын яамнаас өвөлжилт хүндрэх байгалийн давагдашгүй хүчний шинжтэй онцгой байдал бий болзошгүй байгаатай холбогдуулан биотехникийн арга хэмжээнд нийт 3050.0 мянган төгрөгийн санхүүжилт ирснийг 2017 оны 12 дугар сарын 23-29 ны өдрүүдэд 7 чиглэл 51 цэгт өвс, хужир, хорголжин тэжээлийг байршуулан зарцуулсан нь ТХГНТХ-ийн 36.1.5 дахь заалттай нийцэж байна.

2.3. Үйл ажиллагааны зардлыг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан, байгаль орчны нөхөн сэргээх зардлаас 22.8 хувийг үндсэн үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

2017 онд нийт үйл ажиллагааны зардлыг нийт 136632.4 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 136632.4, нэмэлт санхүүжилтээр 3198.0, нийт 139830.4 мянган төгрөгөөр санхүүжиж, 138518.6 мянган төгрөгийг зарцуулж, 1311.8 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

Тухайн онд гэрэл цахилгааны зардлыг 999.2, цэвэр бохир усны зардлыг 1529.1 мянган төгрөгөөр хэмнэлтийг түлш халаалтын зардлын зардлын хэтрэлт 2528.3 төгрөгт, шуудан холбоо, интернэтын зардлыг 7.3 мянган төгрөгийн хэмнэлтийг бичиг хэргийн зардалд тус тус бүлэг дотор шилжүүлэн зарцуулсан байна.

Байгууллагын үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлийг шалгахад дараахь зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 41.2.2, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.5, Сангийн сайдын 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 7-дугаар тушаалыг зөрчин урсгал засварын түлш халаалтын зардлаас 202.0 мянган төгрөгийг урсгал завсварын зардалд, цэвэр бохир усны зардлаас 181.5, түлш халаалтын зардлаас 202.0 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас томилолтын зардалд 313.2, гэрэл

цахилгааны зардалд 41.2, урсгал засварын зардалд 242.3 мянган төгрөгийг тус тус бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан байна.

- Төсвийн тухай хуулийн 16.5.5.-д “батлагдсан төсвийг зориулалтын дауу зарцуулах”, Төсвийн тухай хуулийн 26.1, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын холбогдох заалтыг зөрчин шатахууны зардлаас 206.3 мянган төгрөгийг бараа материалын тайланд орлогод бүртгээгүй шууд зардалд бичсэн зөрчилд төлбөр тогтоон аудитын явцад барагдуулан ажиллаа.

Одоогийн хууль эрх зүйн хүрээнд улсын төсвөөс хуваарилсан санхүүжилтээр байгалийн цогцолборт газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж байна. Уг төсвийн цалин, нийгмийн даатгалын зардалд болон бусад даатгал шимтгэл, бараа хангамж бичиг хэргийн зардал болон бусад урсгал засварт 90.1 хувь, үлдсэн 9.9 хувь нь менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулагджээ.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлаас гадна Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд 7920.0, ургамал хамгаалах зардалд 2251.7 мянган төгрөгийг тухайн онд баталсан байна.

Уг зардлыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаал, НБББББ-т байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалтын ажил, талхлагдсан газрыг нөхөн сэргээх, байгаль орчны хамгаалалын ажилд олон нийтийг оролцуулах, булаг шанд, рашаан, усны эхийг хамгаалах, тохижуулах зардлуудад, ургамал хамгааллын зардлыг ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, эргүүл, пост ажиллуулах, хорхойтсон ой, ховордсон биологийн төрөл зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх, ТХГН-ийн ойд ойн аж ахуйн арга хэмжээг батлагдсан журмын дагуу зарцуулах, амьтаны амьдрах орчныг сайжруулах, биотехникийн арга хэмжээнд зарцуулахаар тус тус тусгайлан заажээ. Тухайн зардлын гүйцэтгэлийг шалган үзэхэд:

Байгаль орчны нөхөн сэргээх зардлын 74.2 хувь буюу 5881.3 мянган төгрөгийг тушаалын дагуу буюу хяналт шалгалтын ажлын шатахууны зардалд 3331.7, булгийн эх хашах зардалд 792.0, ажиглалтын цамхаг барих зардалд 1500.0, тэмдэг тэмдэглэгээний зардалд 59.4, сурталчилгааны материалын зардалд 198.1 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан, 22.8 хувь буюу мянган 1809.4 төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардал буюу цахим сургалтын зардалд 248.5, шуудан холбооны зардалд 36.0, машины даатгалын зардалд 79.5, газрын төлбөр 14.4, хог хаягдлын хураамжийн зардалд 89.8, урсгал засварын зардалд 361.9, томилолтын зардалд 378.7, цэцгийн сав, суулгацын зардалд 600.6 мянган төгрөгийг, ургамал хамгаалах нөхөн сэргээх зардлыг 100 хувь буюу 2251.7 мянган төгрөгийг шатахууны зардалд тус тус зарцуулсан Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаалтай нийцэхгүй байна.

Дээрхээс дүгнэхэд үндсэн үйл ажиллагааны зардал, байгаль хамгаалах нөхөн сэргээх зардал, ургамал хамгаалах зардлыг батлагдсан төсвийн дагуу, төсвийн хязгаарт нь багтааж зарцуулах, цаашид байгаль хамгаалах нөхөн сэргээх зардал, ургамал хамгаалах зардлыг сайдын тушаалын дагуу төлөвлөн зарцуулах шаардлагатай байна.

2.4. Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан санхүүгийн тайланд тусгасан байна.

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаар авлага, өглөгийн эхний болон эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан ба зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримтруу тулган мөн тооцоо нийлсэн актыг тулган баталгаажуулхад Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалт, ННБ-ийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6-д заасан заалтуудтай бүрэн нийцэж байна.

2.5. Хөрөнгийн тооллого, тооцоо, хадгалалт хамгаалалт, ашиглалт сайн байна.

ТБОНӨТХ-ийн 70, 72 дугаар зүйл, НББ-ийн тухай хуулийн 11.1, 11.3 дугаар зүйлд заасны дагуу 2017 оны 07 дугаар сарын 07, 2017 оны 12 дугаар сарын 27-ны 18 дугаар тушаалаар хөрөнгийн тооллого, тооцоог хугацаанд нь хийсэн, 38500.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 22390.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 7596.3 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 1118.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тухай бүрт нь бүртгэл тайландаа тусгасан, цаашид ашиглагдахгүй болсон 16027.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 585 тоот тогтоолын дагуу акталсан байна.

Машин тоног, төхөөрөмж, үндсэн хөрөнгийг дансанд бүртгэлд байгаа хөрөнгийг тулган түүврийн тооллого, бараа материалын дансанд үлдэгдлээр байгаа шатахууны үлдэгдэл талон, нэвтрэх хураамжийн тасалбарт тооллого хийхэд хөрөнгийн хадгалалт хамгаалалтын бүрэн бүтэн байдал зөрчилгүй сайн байгаа нь саашаалтай байна.

Бараа материалын бүртгэл тайланг үзэхэд ННБОУС-16-д “Үндсэн хөрөнгө гэж дараахи шалгуурыг хангасан хөрөнгийг хэлнэ а/ үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, түрээс эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглаж байгаа б/ нэгээс дээш тайлант хугацаанд ашиглагдах хөрөнгийг хэлнэ” гэж заасныг зөрчин бараа материалын хангамжийн дансанд 3872.1 мянган төгрөгийн тавилга, хэрэгслийг бүртгэсэн зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлээ.

*Булган аймаг дахь
Төрийн Аудитын газар*

Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Бүлэг 3

Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалттай байна.

Байгууллагын 2017 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд нийцлийн аудитыг хийсэн бөгөөд аудитаар Шилэн дансны тухай хуулийн 4.1.3 дахь “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлддэг байх” 6.4.8 дахь “... төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”-ийг мэдээллэх гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах, нөхөн байршуулах албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Булган аймаг дахь
Төрийн Аудитын газар

**ХТБЦГЗ-нд хэрэгжиж байгаа хууль, журам
хэрэгжилтийн үр дүн**

Дүгнэлт, Зөвлөмж

ХТБЦГЗ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5, 26.1, 41.2.2, НББОУС-16 дахь заалтуудыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Дүгнэлт:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын үр дүнд үндэслэн дүгнэхэд Хөрөнгийн тооллого, тооцоо, хадгалалт хамгаалалт, ашиглалт сайн, бусад төсөл сангаас хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, холбогдох хууль, дүрэм журамд нийцсэн нь сайшаалтай байгаач зарим холбогдох хууль, дүрэм, тушаал шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Үүнд:

- Үйл ажиллагааны төлөвлөгөө болон үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ 79.8 хувьтай биелүүлсэн байна.
- Нэг байгаль хамгаалагчийн хариуцах тайлбайн хэмжээ нь дунджаар 28130 га талбай хариуцаж байгаа нь Засгийн газрын 2006 оны 87 дугаар тогтоолоор байгаль хамгаалагчийн хариуцан хамгаалах талбайн хэмжээг тусгай хамгаалалттай газрын анилал, байгалийн бүс, бүслүүрийн онцлогоос шалтгаалж тал хээрийн бүсэд 100000 га талбайгаар тогтоосон байдагтай нийцэхгүй, нэг байгаль хамгаалагчид 1 дахин илүү газар ногдож байна.
- Үйл ажиллагааны орлогын төлөвлөлтийг бодитой тоо, тооцоо судалгаанд үнэдэслэдэггүй, зөвхөн өмнөх онуудын төлөвлөлтөнд тулгуурлан төлөвлөдөг байна.
- Нийт 1182.2 мянган төгрөгийн үйл ажиллагааны зардлыг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан, байгаль орчны нөхөн сэргээх зардлын 22.8 хувийг үндсэн үйл ажиллагааны зардалд, ургамал хамгаалах зардлыг 100 хувь шатахууны зардалд зарцуулсан нь холбогдох дүрэм, журам, тушаалтай нийцэхгүй байна.
- Бараа материалын хангамжийн дансанд 3872.1 мянган төгрөгийн тавилга, хэрэгслийг бүртгэсэн. зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлээ.
- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгалтын мөрөөр нөхөн байршуулсан байна.

Зөвлөмж:

Аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хөгнө тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга Д.Эрдэнэчимэг, нягтлан бодогч Д.Ганболд нарт зөвлөж байна.

1. Үйл ажиллагааны төлөвлөгөө болон үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үндсэн үүргээ бүрэн биелүүлэн ажиллаж, дотоод хяналтыг сайжруулах.
2. Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг бодитой тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх, цаашид өөрийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлэхэд идэвхи санаачлагатай ажиллах.
3. Үндсэн үйл ажиллагааны зардал, байгаль хамгаалах нөхөн сэргээх зардал, ургамал хамгаалах зардлыг батлагдсан төсвийн дагуу, төсвийн хязгаарт нь багтааж зарцуулах, цаашид байгаль хамгаалах нөхөн сэргээх зардал, ургамал хамгаалах зардлыг сайдын тушаалын дагуу төлөвлөн зарцуулах.
4. Бараа материалын хангамжийн дансанд 3872.1 мянган төгрөгийн тавилга, хэрэгслийг бүртгэсэн зөрчлийг арилгах.

Мэдэгдэл:

Нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилган, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт гарсан үр дүнгийн талаар 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэх.

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Г.НАМЧИНСҮРЭН

ÒÀÉËÀÍ ÁÈ×ÑÝÍ:

АУДИТОР

Г.НАМЧИНСҮРЭН

ÒÀÍÈËÖÀÆ ÇªÂØªªÐÑªí:

ХТБЦГХЗ-НЫ ДАРГА

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

НЯГТЛАН БОДОГЧ

Д. ГАНБОЛД

Хавсралт -1

- БЦГ-ын хилийн заагийг УИХ болон ЗГ-ын тогтоолоор батласан эргэлтийн цэг, өндрийн тоотуудын солбицлуудтай тулган хянах, нарийвчлалыг шалгах ажлыг зохион байгуулах ажил хариуцсан мэргэжилтэн амралттай /жирэмсний/ байсан шалтгаанаар хийгдээгүй
- Аялал жуучлалын баазууд, эко гэрүүд, эко гэрүүд, эзо аялал жуучлалын зориулалттай байр сууц үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6426: 2013 стандартыг мөрдүүлэх ажил 50 хувьтай
- Аялал жуучлалын зориулалтаар үйл ажиллагаа явуулж буй иргэн ААНБ-уудад хууль эрх зүйн завлагаа, уулзалт зохион байгуулах ажил 50 хувьтай
- БЦГ-т байрлах өвөлжөө хаьаржааны газар ашиглалтад холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулалт хийх ажил 50 хувьтай
- Газар ашиглаж байгаа ААНБ-ын мэдээллийг нэгтгэж ArcGIS программтай холбох ажил 50 хувьтай
- Тахилт нуурын эрэгт шувууны ажишлалтын цамхаг 1, эүүдлийн шувууны үүр 2-ыг хийж байрлуулах ,ТХГН-ын аялалын маршрутын дагуу түр амрах цэг 3-ыг барьж, тохиржуулах ажил 25 хувьтай тус тус биелүүлжээ.

19.1. Хамгаалалтын бүсэд байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэй дараах үйл ажиллагаа явуулж болно:

20.1.4. тухайн нутаг дэвсгэр дэх сууринг ногоон хөгжлийн бодлого зарчимд нийцсэн ерөнхий төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийн дагуу хөгжүүлэх.

36.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа /цаашид "хамгаалалтын захиргаа" гэх/ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

36.1.1. тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх хууль тогтоомж, хамгаалалтын дэглэм, горимын хэрэгжүүлэх;

36.1.2. тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;

36.1.3. тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээний ажил явуулах иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, судалгааны тайлан, үр дүнг хүлээн авах;

36.1.4. тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэм, горимд нийцүүлэн амьтны сүргийн бүтцийг зохицуулах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, ойд арчилгаа, цэвэрлэгээ, ойжуулалт хийх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

36.1.5. амьтанд зориулан үс задгайлах, хадлан бэлтгэх, өвс тэжээл, хужир, шүү тавих, нөмөр хорго барих болон хамгаалах бүсад арга хэмжээг гүйцэтгэх;

36.1.6. тусгай хамгаалалттай газар нутагт явуулах аялал жуулчлалын зам, чиглэлийг батлах, аяллын жим, түр отоглох цэг, тэмдэг, тэмдэгжүүлэлтийг стандартын дагуу хийх, засаж тохижуулах;

36.1.7. байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, орчны бүсийн дэд хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнд зарцуулах төсвийг Засаг даргатай хамтран боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, батлуулах;

36.1.8. улсын тусгай хамгаалалттай газрын мэдээллийг бүрдүүлж, холбогдох байгууллагад хүргүүлэх;

36.1.9. зөвшөөрөгдсөн бүсэд авто зам, гүүр, дэд бүтэц, барилга байгууламж барих ажлыг зориулалт, батлагдсан зураг, стандарт, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байгаад хяналт тавих;

36.1.10. тусгай хамгаалалттай газрын орчны бүсэд байгалийн гамшиг, ган зуд тохиолдсон үед, хамгаалалтын дэглэм, горим, бэлчээрийн нөөц даацад нийцүүлэн зөвшөөрлийн дагуу уламжлалт аргаар мал бэлчээрлүүлэх, хадлан бэлтгэх ажлыг гэрээний үндсэн дээр зохион байгуулах;

36.1.11. хөнөөлт шавж, мэрэгч, түймрээс урьдчилан сэргийлэх, байгалийн гамшиг, ам

Гэр кэйф буулгаж байгаа үүн дээр хяналт тавьж ажиллаагүй гэр барьж айлуудыг буулган жуулчилан ажилласан.